



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 16/03

Баянбулаг

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон  
нутгийн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.20 дугаар заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.5, 27 дугаар зүйлийн 27.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит XVI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: 1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Гишүүд: 2. Засаг дарга

3. Засаг даргын орлогч

4. Засаг даргын тамгын газрын дарга

5. Ерөнхий боловсролын сургуулийн захирал

6. Эрүүл мэндийн төвийн дарга

7. Соёлын төвийн дарга

8. Цэцэрлэгийн эрхлэгч

9. Цаг уур өртөөний дарга

10. Мал эмнэлгийн тасгийн дарга

11. Хөдөө аж ахуйн тасгийн дарга

12. Байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагч

13. Газрын даамал

14. Багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Эрэн хайх аврах бүлгийн дарга

2. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн ажлын жилийн төлөвлөгөөг боловсруулж, үр дүнтэй ажиллан хэрэгжилтийг 2024 оны III улирлын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар тайлагнахыг Зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ДАРГА



Б.НАМГАРРЕНЧИН

648803106